



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Сүхбаатар

“Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага,
ёс зүйг дээшлүүлэх жил” болгон
зарлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.4.3 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймаг сумдад үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, албан хаагчдын ажил үйлчилгээний үр дүн, цаг үеийн шаардлага, төрийн үйлчилгээ хүртэгч иргэдийн сэтгэл ханамжийн үнэлэмж зэргээс дүгнэлт хийж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Олон нийтийн оролцоо-төрийн үйлчилгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 оныг аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд төрийн албан хаагчийн ажлын хариуцлагыг дээшлүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, ажил албаныхаа онцлог нөхцөл байдалд тулгуурлан бодлого зорилт дэвшүүлсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг төр, төсвийн нийт байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг хянах, удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА